



# ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

I-III/2025

Тархаасан: 2025 оны 5 дугаар сарын 16

## ДНБ, 2025 оны эхний улиралд 2.4 хувиар өслөө.

### 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2025 оны эхний улиралд 19.0 их наяд төгрөг болж, өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 2.5 (15.2%) их наяд

төгрөгөөр өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 1.1 (18.6%) их наяд төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 1.0 (15.1%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.

### ХҮСНЭГТ 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

Үзүүлэлт	Жил		Эхний 3 сард			2025* I-III 2024* I-III	
	2023	2024*	2023 I-III	2024* I-III	2025* I-III	дүн	хувь
	тэрбум төгрөг						
ДНБ	70 441.5	79 956.3	13 970.8	16 464.9	18 968.5	2 503.6	15.2
Хөдөө аж ахуй	6 988.2	5 904.6	410.9	383.9	549.0	165.1	43.0
Уул уурхай, олборлолт	19 814.1	21 802.1	5 125.2	5 838.4	6 925.9	1 087.5	18.6
Үйлдвэрлэл, барилга	8 035.3	8 635.6	1 412.9	1 575.7	1 782.7	207.0	13.1
Үйлчилгээ	28 911.6	35 317.9	5 601.6	6 835.2	7 866.1	1 030.9	15.1
Бүтээгдэхүүний цэвэр татвар	6 692.4	8 296.0	1 420.2	1 831.7	1 844.8	13.1	0.7

\* Урьдчилсан гүйцэтгэл

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр 2015 оны зэрэгцүүлэх үнээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2025 оны эхний улиралд 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 143.9


(2.4%) тэрбум төгрөгөөр өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 61.8 (35.6%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарынх 72.2 (2.2%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

### ХҮСНЭГТ 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

Үзүүлэлт	Жил		Эхний 3 сард			2025* I-III 2024* I-III	
	2023	2024*	2023 I-III	2024* I-III	2025* I-III	дүн	хувь
	тэрбум төгрөг						
ДНБ	30 567.1	32 053.9	5 629.8	6 076.8	6 220.7	143.9	2.4
Хөдөө аж ахуй	3 873.3	2 761.1	230.5	173.3	235.0	61.8	35.6
Уул уурхай, олборлолт	3 867.2	4 286.3	807.9	915.4	922.3	7.0	0.8
Үйлдвэрлэл, барилга	4 182.3	4 288.0	629.0	678.0	704.7	26.7	3.9
Үйлчилгээ	14 837.0	16 297.3	3 046.8	3 274.4	3 346.4	72.0	2.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	3 807.3	4 421.1	915.6	1 035.8	1 012.2	- 23.5	- 2.3

\* Урьдчилсан гүйцэтгэл


## ЗУРАГ 1. ДНБ (УЛИРЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАСАН)-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР, ӨМНӨХ УЛИРЛААС



ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр 2015 оны зэрэгцүүлэх үнээр үйлдвэрлэлийн аргаар улирлын нөлөөллийг арилган тооцсон) 2025 оны эхний улиралд өмнөх улиралтай харьцуулахад 0.4 хувиар өслөө.

ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2023 оны эхний улиралд 8.0 хувь, 2024 оны эхний улиралд 7.9 хувь, 2025 оны эхний улиралд 2.4 хувиар тус тус өссөн байна.

## ЗУРАГ 2. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР (2015 ОНЫ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР, ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС)



## ХҮСНЭГТ 3. ДНБ-ИЙ ӨӨРЧЛӨЛТӨД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО

Салбар	Жил		Эхний 3 сард		
	2023	2024*	2023 I-III	2024* I-III	2025* I-III
	нэгж хувь				
<b>ДНБ-ий өсөлт, бууралт, %</b>	<b>7.4</b>	<b>4.9</b>	<b>8.0</b>	<b>7.9</b>	<b>2.4</b>
Хөдөө аж ахуй	- 1.3	- 3.6	- 0.2	- 1.0	1.0
Уул уурхай, олборлолт	2.6	1.4	5.1	1.9	0.1
Үйлдвэрлэл, барилга	0.7	0.3	- 0.3	0.9	0.4
Боловсруулах	0.4	- 0.1	- 0.5	0.3	0.2
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.1	0.1	0.2	0.3	0.2
Барилга	0.1	0.3	0.0	0.2	0.0
Үйлчилгээ	4.7	4.8	4.1	4.0	1.2
Бөөний, жижиглэн худалдаа	0.8	0.7	1.1	0.7	- 0.6
Тээвэр	1.8	1.3	2.2	1.3	- 1.2
Мэдээлэл, холбоо	0.5	0.5	0.2	0.9	0.6
Үйлчилгээний бусад	1.7	2.2	0.6	1.2	2.4
Бүтээгдэхүүний цэвэр татвар	0.8	2.0	- 0.7	2.1	- 0.4

\* Урьдчилсан гүйцэтгэл

ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2025 оны эхний улиралд 2.4 хувиар өссөний 1.0 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 0.1 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.4 нэгж хувийг үйлдвэрлэл,

барилгын салбар, 1.2 нэгж хувийг үйлчилгээний салбар, -0.4 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлсэн байна.

## 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр эцсийн ашиглалтын аргаар тооцсон) 2025 оны эхний улиралд 19.0 их наяд төгрөг болж, өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 2.0 (11.5%) их наяд төгрөгөөр өслөө.

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр 2015 оны зэрэгцүүлэх үнээр эцсийн ашиглалтын аргаар тооцсон) 2025 оны эхний улиралд 6.8 их наяд төгрөг болж, өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 161.6 (2.4%) тэрбум төгрөгөөр өслөө.

### ХҮСНЭГТ 4. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, оны үнээр

Үзүүлэлт	Жил		Эхний 3 сард			2025* I-III 2024* I-III	
	2023	2024*	2023 I-III	2024* I-III	2025* I-III	дүн	хувь
	тэрбум төгрөг						
<b>ДНБ</b>	<b>71 201.6</b>	<b>80 048.8</b>	<b>14 695.1</b>	<b>17 079.7</b>	<b>19 045.4</b>	<b>1 965.7</b>	<b>11.5</b>
Эцсийн хэрэглээ	40 524.0	52 840.4	9 036.4	11 977.4	14 298.5	2 321.1	19.4
Өрхийн хэрэглээ <sup>1</sup>	31 362.2	39 803.4	7 178.8	9 042.2	11 251.1	2 208.9	24.4
Төрийн байгууллагын хэрэглээ	9 161.9	13 037.0	1 857.6	2 935.2	3 047.4	112.2	3.8
Хөрөнгийн нийт хуримтлал	23 879.9	27 700.1	3 505.7	4 727.0	6 609.0	1 882.0	39.8
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	17 839.8	21 430.1	3 007.0	3 568.7	5 142.1	1 573.4	44.1
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт <sup>2</sup>	6 040.1	6 269.9	498.7	1 158.3	1 466.9	308.6	26.6
Цэвэр экспорт	6 797.6	- 491.7	2 153.0	375.4	- 1 862.1	- 2 237.4	-
Бараа, үйлчилгээний экспорт	53 716.7	55 280.4	12 566.4	12 565.4	10 976.8	- 1 588.6	- 12.6
Бараа, үйлчилгээний импорт (-)	46 919.1	55 772.1	10 413.4	12 190.1	12 838.9	648.8	5.3

\* Урьдчилсан гүйцэтгэл

<sup>1</sup> Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

<sup>2</sup> Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

### ХҮСНЭГТ 5. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

Үзүүлэлт	Жил		Эхний 3 сард			2025* I-III 2024* I-III	
	2023	2024*	2023 I-III	2024* I-III	2025* I-III	дүн	хувь
	тэрбум төгрөг						
<b>ДНБ</b>	<b>30 441.5</b>	<b>31 977.5</b>	<b>6 155.7</b>	<b>6 645.7</b>	<b>6 807.3</b>	<b>161.6</b>	<b>2.4</b>
Эцсийн хэрэглээ	26 172.9	29 870.6	5 711.0	6 875.5	7 434.1	558.6	8.1
Өрхийн хэрэглээ <sup>1</sup>	20 268.9	22 883.2	4 596.7	5 377.7	6 018.4	640.7	11.9
Төрийн байгууллагын хэрэглээ	5 904.0	6 987.3	1 114.3	1 497.8	1 415.7	- 82.1	- 5.5
Хөрөнгийн нийт хуримтлал	12 733.0	15 553.9	2 126.5	2 960.1	3 556.1	595.9	20.1
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	9 616.8	11 513.2	1 790.2	2 166.5	2 824.6	658.1	30.4
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт <sup>2</sup>	3 116.2	4 040.7	336.3	793.7	731.5	- 62.2	- 7.8
Цэвэр экспорт	- 8 464.4	- 13 447.0	- 1 681.8	- 3 189.9	- 4 182.9	- 992.9	-
Бараа, үйлчилгээний экспорт	20 500.2	20 640.6	4 740.6	4 299.7	3 526.0	- 773.7	- 18.0
Бараа, үйлчилгээний импорт (-)	28 964.6	34 087.7	6 422.4	7 489.6	7 708.9	219.3	2.9

\* Урьдчилсан гүйцэтгэл

<sup>1</sup> Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

<sup>2</sup> Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

ДНБ-ий 2.4 хувийн өсөлтийн 8.4 нэгж хувь нь эцсийн хэрэглээнд, 9.0 нэгж хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, -14.9 нэгж хувь нь цэвэр экспортод ногдож байна.

Эцсийн хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 7.4 их наяд төгрөг болж, өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 558.6 (8.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

## ХҮСНЭГТ 6. ДНБ-ИЙ ӨӨРЧЛӨЛТӨД БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ОРОЛЦОО

Бүрэлдэхүүн	Жил		Эхний 3 сард		
	2023	2024*	2023 I-III	2024* I-III	2025* I-III
	нэгж хувь				
ДНБ-ий өсөлт, бууралт, %	7.2	5.0	7.9	8.0	2.4
Эцсийн хэрэглээ	7.0	12.1	4.1	18.9	8.4
Өрхийн хэрэглээ <sup>1</sup>	6.3	8.6	2.0	12.7	9.6
Төрийн байгууллагын хэрэглээ	0.7	3.6	2.0	6.2	- 1.2
Хөрөнгийн нийт хуримтлал	- 1.6	9.2	- 6.6	13.5	9.0
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1.7	6.2	4.0	6.1	9.9
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт <sup>2</sup>	- 3.3	3.0	- 10.6	7.4	- 0.9
Цэвэр экспорт	1.8	- 16.4	10.4	- 24.5	- 14.9
Бараа, үйлчилгээний экспорт	18.0	0.5	44.4	- 7.2	- 11.6
Бараа, үйлчилгээний импорт (-)	17.3	16.8	34.0	17.3	3.3

\* Урьдчилсан гүйцэтгэл


<sup>1</sup> Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

<sup>2</sup> Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

Өрхийн эцсийн хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 6.0 их наяд төгрөг болж, өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 640.7 (11.9%) тэрбум төгрөгөөр өсөж, ДНБ-д 9.6 нэгж хувиар эерэг нөлөө үзүүлсэн байна.

Төрийн байгууллагын хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 1.4 их наяд төгрөг болж өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 82.1 (5.5%) тэрбум төгрөгөөр буурч, ДНБ-д 1.2 нэгж хувиар сөргөөр нөлөөлжээ.


### ЗУРАГ 3. ӨРХИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС, ХУВИАР



Хөрөнгийн нийт хуримтлал (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 3.6 их наяд төгрөг болж өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 595.9 (20.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Үүнд үндсэн хөрөнгийн нийт хуримтлал 2.8 их наяд төгрөг болж өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 658.1 (30.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

### ЗУРАГ 4. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН НИЙТ ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ, БУУРАЛТ, ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС, ХУВИАР




Бараа үйлчилгээний цэвэр экспорт (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2025 оны эхний улиралд 4.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

Бараа үйлчилгээний экспорт (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 3.5 их наяд төгрөг болж өмнөх оны эхний

улиралтай харьцуулахад 773.7 (18.0%) тэрбум төгрөгөөр буурсан бол бараа, үйлчилгээний импорт 7.7 их наяд төгрөг болж өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 219.3 (2.9%) тэрбум төгрөгөөр өсжээ.

### ЗУРАГ 5. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭКСПОРТ, ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, их наяд төгрөгөөр



Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр орлого 2025 онд эхний улиралд 2.0 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан бол Хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлэг 481.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2025 онд эхний улиралд Үндэсний нийт орлого 16.9 их наяд төгрөг, Үндэсний нийт эзэмшлийн орлого 17.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Өмнөх оны эхний улиралтай харьцуулахад Үндэсний нийт орлого 15.9 хувиар, Үндэсний нийт эзэмшлийн орлого 14.5 хувиар тус тус өслөө.

### ХҮСНЭГТ 7. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр

Үзүүлэлт	Жил		Эхний 3 сард			2025* I-III / 2024* I-III	
	2023	2024*	2023 I-III	2024* I-III	2025* I-III	дүн	хувь
	тэрбум төгрөг						
<b>ДНБ</b>	70 441.5	79 956.3	13 970.8	16 464.9	18 968.5	2 503.6	15.2
Гадаад эдийн засгаас хүлээн авсан анхдагч орлого, цэвэр	- 7 725.5	- 9 089.7	- 1 521.7	- 1 853.2	- 2 039.7	- 186.6	10.1
<b>ҮНО</b>	62 716.0	70 866.6	12 449.1	14 611.7	16 928.8	2 317.0	15.9
Гадаад эдийн засгаас хүлээн авсан хоёрдогч орлого, цэвэр	1 381.3	1 516.4	477.0	592.6	481.4	- 111.2	- 18.8
<b>ҮНЭО</b>	64 097.3	72 382.9	12 926.0	15 204.3	17 410.1	2 205.8	14.5

\* Урьдчилсан гүйцэтгэл

## Ойлголт, тодорхойлолт:

**Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ):** Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тайлант хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг дараах 3 аргаар тооцно.

**Үйлдвэрлэлийн арга:** Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг,

**Эцсийн ашиглалтын арга:** Эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт, импортын зөрүү) нийлбэрээр тооцохыг,

**Орлогын арга:** Ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг ойлгоно.

**Үндэсний нийт орлого (ҮНО):** Тухайн улсын эдийн засгийн харьяатуудын шинээр бий болгосон нэмэгдсэн өртөг бөгөөд ҮНО-ыг тооцохдоо ДНБ-ий гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн анхдагч цэвэр орлогын хэмжээг нэмнэ. Анхдагч орлогод а.харьяат бус ажиллагчдад төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, б.хөрөнгө оруулалтын орлого буюу харьяат, харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хүүгийн орлого орно.

## Эх үүсвэр:

Үндэсний Статистикийн Хороо

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.1212.mn/>

Нэгдсэн статистикийн газрын  
дарга Ц.Тэгшжаргал  
Утас : (976-51)-264805

**Үндэсний нийт эзэмшлийн орлого (ҮНЭО):** ҮНЭО-ыг ҮНО болон харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлгийн нийлбэрээр тооцно. Шилжүүлэг гэдэг нь эдийн засгийн нэг сектор нөгөө сектортоо ямар нэг хариу төлбөр авахгүйгээр өгч байгаа бараа, үйлчилгээ, санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө юм. Урсгал шилжүүлэг нь урсгал татвар, нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, бусад урсгал шилжүүлгээс бүрдэнэ. Зарцуулах боломжтой орлогыг илэрхийлнэ.



## Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 8 дугаар сарын 18

Нэгдсэн статистикийн газрын  
Үндэсний тооцооны хэлтсийн статистикч  
Э.Гэрэлт-Од  
Утас : (976-51)-262767



/StatisticMGL



information@nso.mn



7014-1212